


№12 (151) 2023 оны 12-р сар "ДЦС-4" ТӨХК-ийн сар тутмын сонин

ЭНЭ ДУГААРТ:


ОНЫ ШИЛДГҮҮДЭЭ ШАЛГАРУУЛЛАА — 2,3-р нүүрт

АРХИМЕД-2023 УРАЛДААН — 4-р нүүрт

2023 ОНЫ 12-Р САРЫН ТЭЗУ — 5-р нүүрт

2023 ОНЫ 12-Р САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ — 6-р нүүрт

ЗАЛУУЧУУДЫН ЧУУЛГА УУЛЗАЛТ-2023 — 7-р нүүрт

"ИЛТГЭЛИЙН УРАЛДААН 2023" — 8-р нүүрт


Сонины талаарх санал хүсэлтээ 2125, 2602 дугаарын утас, cxa@tpp4.mn эсвэл СХА-нд файлаар болон бичгээр өгч болно.

www.tpp4.mn

# ОНЫ ШИЛДГҮҮДЭЭ ШАЛГАРУУЛЛАА

**Манай компани Шинэ жилийн баярын хурлаа хийж, өнгөрч буй 2023 ондоо амжилт бүтээлээр бусдыгаа хошуучилан ажилласан ШИЛДЭГ-үүдээ шагнаж урамшууллаа.**

## "ХӨДӨЛМӨРИЙН АВАРГА" АЖИЛТНУУД

| № | Овог нэр | Албан тушаал |
|---|---|---|
| 1 | Цэвсүрэн Дөлгөөн | Түлш дамжуулах цехийн тоноглолын засварчин |
| 2 | Жаргалсүрэн Нямхүү | Зуухан цехийн цахилгаан гагнуурчин |
| 3 | Батмөнх Энхбаяр | Турбин цехийн тохируулга тосолгооны системийн засварчин |
| 4 | Сэсээр Балдорж | Цахилгаан цехийн хуваарилах байгууламж кабель шугамын засвар угсралтын монтёр |
| 5 | Сүхбаатар Бямбадорж | Дулааны хянах хэмжүүр автоматикийн цехийн хэмжүүрийн засварчин |
| 6 | Гантөмөр Бямбажаргал | Химийн цехийн ээлжийн лаборант |
| 7 | Намсрайжав Батжаргал | Механик цехийн өргөх зөөх механизмын цахилгаан тоноглолын засварчин |
| 8 | Чимэддорж Болормаа | Эрчим зоог цайны газрын ээлжийн ахлах тогооч |


ТДЦ-ийн тоноглолын засварчин Ц.Дөлгөөн


ЗЦ-ийн цахилгаан гагнуурчин Ж.Нямхүү


ТЦ-ийн тохируулга тосолгооны системийн засварчин Б.Энхбаяр


ЦЦ-ийн хуваарилах байгууламж кабель шугамын засвар угсралтын монтёр С.Балдорж


ДХХАЦ-ийн хэмжүүрийн засварчин С.Бямбадорж


Эрчим зоог цайны газрын ээлжийн ахлах тогооч Ч.Болормаа

# ОНЫ ШИЛДГҮҮДЭЭ ШАЛГАРУУЛЛАА


МЦ-ийн өргөх зөөх механизмын цахилгаан тоноглолын засварчин Н.Батжаргал


ХЦ-ийн ээлжийн лаборант Г.Бямбажаргал

## "АЖИЛ МЭРГЭЖЛИЙН АВАРГА" АЖИЛТНУУД

| № | Ажил мэргэжлийн аварга | Овог нэр | Албан тушаал |
|---|---|---|---|
| 1 | Инженер техникийн ажилтан | Э.Батсайхан | ЗЦ-ийн халах гадаргуу, арматурын засварын инженер |
| 2 | Мастер | Н.Биелхаан | МЦ-ийн хүчилтөрөгчийн аж ахуйн мастер |
| 3 | Ээлжийн дарга | Ц.Дорждэрэм | ТДЦ-ийн ээлжийн дарга |
| 4 | Машинч | Д.Мөнхдэлгэр | ЗЦ-ийн зуухны машинч |
| 5 | Туслах тоноглолын машинч | Э.Мөнхтөр | ТЦ-ийн туслах тоноглолын щитний машинч |


ЗЦ-ийн халах гадаргуу, арматурын засварын инженер Э.Батсайхан


МЦ-ийн хүчилтөрөгчийн аж ахуйн мастер Н.Биелхаан


ТДЦ-ийн ээлжийн дарга Ц.Дорждэрэм


ЗЦ-ийн зуухны машинч Д.Мөнхдэлгэр


ТЦ-ийн туслах тоноглолын щитний машинч Э.Мөнхтөр

# ОНЫ ШИЛДГҮҮДЭЭ ШАЛГАРУУЛЛАА

## "ХҮНДЭТ САМБАР"-Т АЛДАРШУУЛАХ АЖИЛТНУУД

| № | Овог нэр | Албан тушаал |
|---|---|---|
| 1 | Б.Бямбадорж | СХА-ны электроник, цацраг идэвхт төхөөрөмжийн инженер |
| 2 | Н.Эрдэнэбаяр | ЗА-ны арматур, халах гадаргуун засварчин |
| 3 | А.Идэрбат | ТЦ-ийн хүнд механизмын засварчин |
| 4 | Д.Майнбаяр | ЗЦ-ийн зуух болон тоос бэлтгэх тоноглолын засварчин |
| 5 | Б.Пүрэвжав | ТЦ-ийн цахилгаан гагнуурчин |
| 6 | Ц.Ууганбаатар | ЦЦ-ийн өндөр хүчдэлийн туршилтын монтёр |
| 7 | Х. Ган-Эрдэнэ | ДХХАЦ-ийн токарьчин |
| 8 | П.Түвшинбаяр | ХЦ-ийн тоноглолын завсарчин |
| 9 | Ж.Энхболд | МЦ-ийн шат бэхэлгээний засварчин |
| 10 | Б.Ганболор | НАХ-ийн хувцас угаах тоноглолын машинч, индүүчин |
| 11 | Э.Батсүх | ЗЦ-ийн цахилгаан гагнуурчин |
| 12 | Монгол төрийн их голомт хүндэтгэлийн концерт | Уран бүтээлч ажилтнууд |



2023 оны Аварга цех "Зуухан цех"

## "ХҮНДЭТ АЖИЛТАН ТЭМДЭГ"-ЭЭР ШАГНАГДСАН АЖИЛТНУУД

| № | Овог нэр | Албан тушаал |
|---|---|---|
| 1 | Э.Гүржав | ХА-ны ХАБЭА хяналтын инженер |
| 2 | Ж.Нямбаатар | ЗА-ны арматур, халах гадаргуун засварчин |
| 3 | Б.Баясгалан | СХА-ны архивын мэргэжилтэн |
| 4 | Д.Дашдорж | БМА-ны цахилгаан гагнуурчин |
| 5 | Г.Өлзийдэлгэр | СБХ-ийн тос, шатахуун хариуцсан нярав |
| 6 | Х.Бямбадорж | НАХ-ийн жижүүр цаг бүртгэгч |
| 7 | Х.Доржготов | ТДЦ-ийн вагон хөмрөгчийн машинч |
| 8 | М.Бямбасүрэн | ТДЦ-ийн вагон хөмрөгчийн машинч |
| 9 | С.Азжаргал | ЗЦ-ийн ээлжийн дарга |
| 10 | Д.Баатар | ЗЦ-ийн зуух болон тоос бэлтгэх тоноглолын засварчин |
| 11 | Ч.Бүрэгдхүү | ТЦ-ийн ус хангамжийн засварчин |
| 12 | С.Энхманлай | ЦЦ-ийн ашиглалтын инженер |
| 13 | Г.Өлзийсайхан | ДХХАЦ-ийн хэмжүүрийн засварчи |
| 14 | В.Мөнхбаяр | ХЦ-ийн ээлжийн дарга |
| 15 | Э.Эрдэнэсолонго | МЦ-ийн шахсан агаарын компрессорын машинч |
| 16 | Ё.Бямбаа | ААА-н авто кранчин /20.1тн-40тн/ |
| 17 | Б.Жавзандулам | ЭЗЦГ-ын ээлжийн тогооч |



2023 оны Аварга нэгж "Үйлдвэрлэлийн алба"



2023 оны Спортын шилдэг хамт олон "Зуухан цех"



2023 оны Авто тээврийн салбарын манлай байгууллага "Авто аж ахуй"



2023 оны "Шилдэг залуу" МЦ-ийн өрмийн тоноглолын машинч И.Ариунжаргал



# "АРХИМЕД-2023" УРАЛДААН

АРХИМЕД оюуны шилдэг бүтээлийн шалгаруулалтанд 8 нэгжийн 11 бүтээл нэр дэвшин өрсөлдсөн. /Шалгаруулалтыг 12 сарын 26–нд явуулсан./ 26 оноогоор тэргүүн байранд ЦЦ–ийн Шийдвэр, наряд өгөх урсгалыг "Цахим" хэлбэрт шилжүүлэх, 24 оноогоор дэд байранд "Элсэн цэвэрлэгээний төхөөрөмж" шалгарсан бол санал санаачлагаараа хийсэн ажлын тэргүүн байранд МЦ–ийн "Фрезерийн суурь машинд ширээний шилжилтийн утгыг харуулах дижитал дэлгэц суурилуулсан", ЦЦ–ийн "Цахилгаан шүүлтүүрийн тэжээлийн агрегатуудыг ДТУЩ–1,2–оос алсын удирдлагаар залгаж таслах, горим болон цахилгаан параметрүүдийг хянах", дэд байранд тус тус шалгарлаа.

| № | Овог нэр | Албан тушаал | Бүтээлийн нэр | Эзэлсэн байр | **Шагнал** |
|---|---|---|---|---|---|
| 1 | Д.Амгалан | ЦЦ–ийн электроник программчлал, тохируулгын инженер | **Шийдвэр, наряд өгөх урсгалыг цахим хэлбэрт шилжүүлэх** | Архимед тэргүүн байр | 1.500.000 ₮ "Архимед" алтан цом, медаль, батламж |
| 2 | Э.Намжин | ХЦ–ийн засварын мастер | **Элсэн цэвэрлэгээний төхөөрөмж буу, цэвэршүүлсэн агаар шүүгч, зориулалтын өмсгөл** Санаачлагч: Засварын алба, Гүйцэтгэсэн баг: Засварын мастер Э.Намжин, засварчин Г.Гантулга | Архимед дэд байр | 1.000.000 ₮ "Дурсгалын цом" медаль, батламж |
| 3 | Э.Батболд | МЦ–ийн тоноглолын засварын мастер | **6Т82 Ш маркийн гар ажиллагаатай фрезерийн суурь машинд ширээний шилжилтийн утгыг харуулах дижитал дэлгэц суурилуулан хагас автомат ажиллагаатай болгох** Удирдан зохион байгуулагч: Э.Батболд, Санаачлагч: Н.Батжаргал, Ш.Баттогтох, Хамтран ажилласан Ч.Бат–Од | Санал санаачлагаар хийсэн ажил тэргүүн байр | 350.000₮ батламж |
| 4 | Н.Ганболд | ЦЦ–ийн цахилгаан шүүлтүүрийн цахилгааны инженер | **Цахилгаан шүүлтүүрийн тэжээлийн агрегатууд болох АТПОМ–уудыг ДТУЩ–1,2–оос алсын удирдлагаар залгаж таслах, горим болон цахилгаан параметрүүдийг хянах** Зохиогч гүйцэтгэгч: Н.Ганболд, Д.Амгалан | Санал санаачлагаар хийсэн ажил дэд байр | 300.000₮ батламж |



*ЦЦ-ийн электроник программчлал, тохируулгын инженер Д.Амгалан*



*ХЦ-ийн засварын мастер Э.Намжин*



*МЦ-ийн тоноглолын засварын мастер Э.Батболд*



*ЦЦ-ийн цахилгаан шүүлтүүрийн цахилгааны инженер Н.Ганболд*



# 2023 ОНЫ 12-Р САРЫН ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Төлөвлөгөөний биелэлт

Горимын даалгавараас 1914,476 мян.кВтц цахилгаан эрчим хүч илүү үйлдвэрлэж, 1504,768 мян.кВтц–аар зөрчиж, төлөвлөгөөг 409,708 мян.кВтц–аар давуулан биелүүлсэн. Цахилгаан эрчим хүчний доод ачаалал 610МВт, дээд ачаалал 749 МВт байлаа.

Диспетчерийн графикийн төлөвлөгөөний биелэлт

| Үзүүлэлт | Нэгж | Тухайн сарын | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Төлөв | Гүйц | Зөрүү | Биелэлт,% |
| ЦЭХ-ний түгээлт | сая.кВтц | 467.8 | 468.2 | +0.4 | 100.1% |
| ДЭХ-ний түгээлт | мян.Гкал | 680.0 | 680.0 | - | 100.0% |

Тайлант хугацаанд диспетчерийн зохицуулсан төлөвлөгөө: ЦЭХ – 101,0%, ДЭХ – 100,0% биеллээ.

ДҮТ–ийн диспетчерийн зохицуулсан төлөвлөгөө болон биелэлт

| Нэмэх шийдвэр | | Хасах шийдвэр | | Диспетчерийн графикийн зөрчил | | Ачаалал | | Диспетчерийн төлөвлөгөөний биелэлт | Диспетчерийн графикийн нэмэх зөрчил |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Удаа | мян.кВтц | Удаа | мян.кВтц | Удаа | мян.кВтц | Дээд | Доод | мян.кВтц | мян.кВтц |
| 48 | 1914.476 | 45 | 4639.448 | 2 | 1504.768 | 749 | 610 | 409.708 | - |

## СПОТ зах зээлийн талаар

СПОТ арилжааны зах зээлд 266.216 мян.кВтц буюу 32.9 сая.төгрөгний цахилгаан эрчим хүч худалдаж, СПОТ зах зээлээс 221.069 мян.кВтц буюу 14.2 сая.төгрөгний цахилгаан эрчим хүч худалдаж авсан. Авлага өглөгийн зөрүүгээр 18.7 сая.төгрөгийн ашигтай ажилласан. Өссөн дүнгээр манай станц 178.7 сая.төгрөгийн авлагатай.

## Үйлдвэр санхүүгийн төлөвлөгөөний биелэлт

Цахилгаан эрчим хүчний түгээлтийг төлөвлөлтөөс 24,3 сая.кВтц–аар давуулан 105,5 %–н биелэлттэй, оны эхнээс 213,5 сая.кВтц–аар давуулж, 105,2% –ийн биелэлттэй байна.

Цахилгаан эрчим хүчний түгээлтийг өнгөрсөн оны 12–р сартай харьцуулбал 29,7 сая.кВтц буюу 6,8 %–н өсөлттэй байлаа.

Дулааны эрчим хүчний түгээлт 66,5 мян.Гкал–аар тасарч 91,1%–н биелэлттэй, харин оны эхнээс нийт дулааны төлөвлөгөө 84,2 мян.Гкал–аар, УБДС ХК –д нийлүүлэх дулаан 131,0 мян.Гкал–аар тасарсан байна.

Дулааны эрчим хүчний түгээлтийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал 6,9 мян.Гкал–аар буюу 1,0% өссөн.

## Үндсэн тоноглолын ажиллагаа

Горим ажиллагаанд 8 зуух, 7 турбин оролцсон. Сарын дунджаар 7,92 зуух, 6,95 турбинтэй ажиллаж, бэлтгэлд зуух, турбингүй ажилласан.

## Мазутын зарцуулалт

Энэ сард 120 тн мазут түлэх төлөвлөгөөтэйгээс 43 тн–г түлж, 77 тн мазут хэмнэсэн.

Тайлант хугацаанд 1 удаагийн хүйтэн галлагаанд 19 тн мазут, 2 удаагийн халуун галлагаанд 12 тонн мазут түлсэн.

## Нүүрсний зарцуулалт /ҮСТ тарифт тусгагдсан нүүрснээс/

| Уурхай | Нэгж | Тухайн сарын | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Төлөв | Гүйц | Зөрүү | Биелэлт |
| Багануур | мян.тн | 205.0 | 193.1 | -11.9 | 94.2% |
| Шивээ-Овоо | мян.тн | 200.0 | 175.3 | -24.7 | 87.7% |
| Бүгд | мян.тн | 405.0 | 368.5 | -36.5 | 91.0% |

## Жишмэл түлшний зарцуулалт

Цахилгаан эрчим хүч түгээхэд зарцуулах жишмэл түлш: 16,005 гр/кВтц–аар,

Дулааны эрчим хүч түгээхэд зарцуулах жишмэл түлш: 0,065 кг/Гкал–аар хэмнэж гүйцэтгэлд ноогдох төлөвлөлтөөс 7539 тн жишмэл түлш буюу 15968 тонн бодит түлш /илчлэг 3305 ккал/кг/ хэмнэлээ.

## Горим параметрийн даалгаврын биелэлт

ЭХЗХ –аас батлагдсан ДХЦЭХ–ний зарцуулалтыг 0.36 %–аар буюу 1886.642 мян.кВтц–аар хэмнэж ажилласан.

Нэгж бүтээгдэхүүнд оногдох ЦЭХ–г гүйцэтгэлд ноогдох төлөвлөгөө, өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлтэй тус, тус харьцуулбал:

| № | Үзүүлэлт | Нэгж | 12-р сар | |
|---|---|---|---|---|
| | | | Төлөв | Гүйц |
| 1 | 1 тн нүүрс нунтаглахад зарцуулах цахилгаан | кВтц/тн.нүүрс | 29.89 | 28.95 |
| 2 | 1 тн уур боловсруулахад зарцуулах үлээлт соролтын цах. | кВтц/тн.уур | 4.40 | 4.26 |
| 3 | 1 тн тэжээлийн ус шахахад зарцуулагдах цахилгаан | кВтц/тн.тэж ус | 7.43 | 7.20 |
| 4 | Эргэлтийн усны насосд зарцуулагдах цахилгаан | % | 0.95 | 0.92 |
| 5 | Дулаанжуулалтын насосд зарцуулагдах цахилгаан | кВтц/Гкал | 0.70 | 0.68 |

## Уур усны алдагдал

Станцын дотоод циклийг нөхөх химийн цэвэрлэсэн усны зарцуулалтыг төлөвлөсөн хэмжээнээс 0.84%–аар бууруулж тонн хэмнэж ажилласан. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад химийн цэвэрлэсэн усны зарцуулалт тн–оор буурсан байна.

Дотоод циклийн алдагдлыг нөхөхөөр:

- Зууханд: 162 м$^3$ ус өгсөн.
- БКБ–аас цэвэрлэгдсэн конденсатын зарцуулалт – 18569 м$^3$ байлаа.

Осмосын халаагч уурын зарцуулалт 4648 тн байлаа.

*Үйлдвэрлэлийн алба*



## 2023 ОНЫ 12-Р САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

2023 оны 12–р сард станцын хэмжээний аваари, 1 болон 2–р зэргийн саатал гараагүй, үндсэн тоноглолын зогсолт 5 бүртгэгдсэнээс зуух 3 удаа, турбин 2 удаа зогссон.

| № | Зогсолтын шалтгаан | Хамгаалалтаар | | Захиалгаар | | Бэлтгэлд | | Саатал, гэмтлээр | | Нийт зогсолт | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2022 оны 12-р сар | 2023 оны 12-р сар | 2022 оны 12-р сар | 2023 оны 12-р сар | 2022 оны 12-р сар | 2023 оны 12-р сар | 2022 оны 12-р сар | 2023 оны 12-р сар | 2022 оны 12-р сар | 2023 оны 12-р сар |
| 1 | Зуух | - | - | - | 1 | - | - | 1 | 2 | 1 | 3 |
| 2 | Турбин | - | - | 4 | 1 | - | - | 3 | 1 | 7 | 2 |
| Дүн | | - | - | 4 | 2 | - | - | 4 | 3 | 8 | 5 |

Үндсэн тоноглолын зогсолт болон туслах тоноглолд бичигдсэн актууд:

- Тоног төхөөрөмжийн гэмтлийн акт: СХА–1 (0₮), ДХХАЦ–1 (550,000 ₮), ТДЦ–1 (0 ₮) – Бүгд–3 (550,000 ₮)
- Мазут зарцуулалтын акт: ЗЦ–1 (51,179,591 ₮), ЗА–1 (14,303,232₮) – Бүгд–2 (65,482,823 ₮)
- Тоног төхөөрөмж, сэлбэг материал ашиглалтаас хасах акт: ЗЦ–1 (0₮), ДХХАЦ–1 (0₮), ААА–1 (0₮), ЭЗЦГ–1 (1,241,988 ₮) – Бүгд–4 (1,241,988 ₮)

Нийт 9 ширхэг (67,274,811 төгрөг) акт тогтоогдсон.

Ажлын байрны хөдөлмөрийн нөхцлийн байдалд хийсэн хэмжилт. (Нэг удаагийн)

| № | Цех нэгжүүд | Дуу шуугиан (85 дб) | | Ажлын байрны халуун (12-30 °C) | | Ажлын байрны чийглэг (30-60 %) | | Ажлын байрны тоосролт (10 мг/м³) | | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2022 оны 12-р сар | 2023 оны 12-р сар | 2022 оны 12-р сар | 2023 оны 12-р сар | 2022 оны 12-р сар | 2023 оны 12-р сар | 2022 оны 12-р сар | 2023 оны 12-р сар | |
| 1 | ТДЦ | 81.8 | 77.5 | 11.5 | 11.6 | 40.5 | 47.5 | 13.07 | 18.97 | +5.9 |
| 2 | ЗЦ | 82.6 | 83 | 23.6 | 27.1 | 23.7 | 22.9 | 8.5 | 10.2 | +1.7 |
| 3 | ТЦ | 84.4 | 82.5 | 23.4 | 26.7 | 25.5 | 20.7 | 10.78 | 14.58 | Станцын дундаж тоосролт |
| 4 | Хими | - | 52.9 | - | 23.8 | - | 17.2 | | | |
| 5 | ЦЦ | 74.9 | 77.5 | 22.8 | 17.9 | 26.8 | 19.7 | | | |
| 6 | Механик | 69.4 | 88.6 | 16.3 | 17.7 | 19.0 | 19.3 | | | |

## ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ХЯНАЛТ

| № | Хийгдсэн ажил | Гүйцэтгэл | Тайлбар |
|---|---|---|---|
| | **1. Хяналтын чиглэлээр** | | |
| 1 | Нарядын мөрдөлтөнд хяналт хийсэн байдал | 100% | 47 нарядад давхрдсан тоогоор сонголтоор хяналт хийсэн. |
| 2 | Ажлын байранд хяналт хийсэн байдал | 100% | 20 ажлын байранд эргэлт шалгалтын маршрутын дагуу хяналт тавьсан. |
| 3 | Шинэчлэл, засварын ажлын явцад хяналт хийсэн байдал | - | - |
| | **2. Сургалт, зааварчилгаа** | | |
| 1 | Урьдчилсан зааварчилгаа өгөгдсөн байдал | 100% | 93 хүнд урьдчилсан зааварчилгаа өгсөн. |
| 2 | Шинээр ажилд орж байгаа иргэний сургалтын талаар | - | - |
| 3 | Ажлын байр өөрчлөгдсөн ажилтны сургалтын талаар | 100% | 5 ажилтнаас шалгалт авсан. |
| 4 | Бусад сургалтын талаар | 100% | Зэрэг ахих 6 ажилтнаас шалгалт авсан. |
| | **3. Хөдөлмөрийн эрүүл ахуйн талаар** | | |
| 1 | МХЕГ ХАБҮЛ-тай байгуулсан гэрээний хэрэгжилтэнд хяналт тавих. | 100% | Гэрээ дүгнэгдсэн. |
| 2 | Хөдөлмөрийн нөхцлийн хэмжилт хийх. | 100% | Үндсэн 6 цехд хөдөлмөрийн нөхцлийн хэмжилт хийсэн ХЦ-н шуурхай лабораторид 1 удаа сорох шүүгээний агаарын урсгалын хэмжилт хийсэн. |
| 3 | Ундны усны шүүлтүүр солих ажилд хяналт тавьсан талаар | 100% | Хяналт тавьж байгаа |
| 4 | Ариутгал халдваргүйтгэл шавьж мэрэгчийн устгал хийсэн талаар | 100% | 4 ажлын байранд мэрэгчийн хор тавьсан.. |
| 5 | Тоосролтын хэмжилтэнд хяналт хийсэн байдал | 100% | Нийт 4 удаа хэмжилт хийгдсэн. |
| | **4. Бусад ажлын талаар** | | |

- Албаны үндсэн хөрөнгийн тооллого хийж актлах хөрөнгийн жагсаалт гаргаж СБХ–т өгсөн. Агуулах №12,13 тооллого хийсэн. Ажлын байруудаар хяналт шалгалт хийсэн.
- Эрчим хүчний хөгжлийн төвтэй аюулгүй ажиллагаатай холбоотой ном захиалах талаар ярьж ХААХ–д мэдэгдэж гэрээ хийж захиалсан.
- Аюулгүй ажиллагааны эрхийн үнэмлэх авах талаар холбогдох нэгжүүдтэй уулзаж гэрээ байгуулж ЭХ Хөгжлийн төвд захиалга өгсөн.. АА эрхийн үнэмлэх 1500ш хэвлүүлэх хүсэлд гаргаж захиалга өгч ХААХ–д мэдэгдэж тохирсон..
- Энх–Оршихуй уралдааны удирдамж батлуулахаар гүйцэтгэх захирлд танилцуулж Энх–Оршихуй уралдааны комисс удирдамжийн дагуу цех, нэгжүүдээр явж шалгаруулалт хийсэн. Шалгарсан цех, хамт олон, хувь хүмүүст баярын хурал дээр шагналыг гардуулсан..
- Ажил олгогчийн сургалтын гэрээ дүгнэх акт үйлдэж дүгнүүлсэн.
- ХАБЭА–н 2023 оны тайлан бичиж гаргасан.

*Хяналтын алба*

# “ЗАЛУУЧУУДЫН ЧУУЛГА УУЛЗАЛТ-2023”

Станцын Залуучуудын холбооноос зохион байгуулсан “Залуучуудын чуулга уулзалт-2023” сургалтын арга хэмжээ 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдөр амжилттай зохион байгуулагдлаа. Энэ сургалт өмнө нь 2019 онд зохион байгуулагдсан ба дөрвөн жилийн дараа зохион байгуулагдсанаараа онцлог байлаа.

Сургалтад станцын төлөөлөл болсон нийт 100 залуу хамрагдсан.

Уг арга хэмжээний зорилго нь залуучуудыг ажлын байранд тогтвор суурьшилтай ажиллах нөлөөлөл үзүүлэхэд оршсон ба сургалтын агуулга доорх сэдэв рүү чиглэгдсэн. Сэтгэл судлаач П.Ариунаа “Ажлаас халшрах хам шинжүүд, тэдгээрийг давах арга замууд”, Монголын хүний нөөцийн ассоциацийн захирал, дэд профессор С.Наранбаатар “Ажилд хандах хандлага, ирээдүйд бий болох үнэ цэнэ”, “Байгууллагын уур амьсгал ажлын бүтээмжид хэрхэн нөлөөлөх вэ” сэдвүүдээр сургалт лекц орсон. Мөн сургалтад компанийн гүйцэтгэх захирал Ү.Төмөрхуяг, ерөнхий инженер П.Болдбаатар, захиргаа хүний нөөцийн албаны дарга Ш.Туухайнжин нар хүрэлцэн ирж залуучуудаа урмын үгээр тэтгэж мэндчилгээ дэвшүүлсэн.

Сургалтын явцад залуучууд маань өөрсдийн дуу хоолойг индэр дээрээс чөлөөтэй илэрхийлж байлаа. Залуучуудын холбооны зүгээс сургалтын үеэр хэлэлцэгдсэн санал санаачилгуудыг нэгтгэж станцын захиргаа болон удирдлагуудад уламжлахаар бэлтгэж байна.







# "ДЦС-4" ТӨХК БОЛОН "УБЦТС" ТӨХК-ИЙН ЗАЛУУЧУУДЫН ХОЛБОО ХАМТАРСАН E-SPORT-ЫН АНХДУГААР ТЭМЦЭЭН

**PUBG**

| Байр | Компани | Баг |
|---|---|---|
| 1 | "ДЦС-4" ТӨХК ЦЦ | "ZS" баг |
| 2 | "УБЦТС" ТӨХК | "Gunsb" баг |
| 3 | "ДЦС-4" ТӨХК ХА | "Emoji" баг |

*Шилдэг тоглогч*

"ДЦС-4" ТӨХК-ийн ТДЦ-ийн "ZS" багийн тоглогч FLAME

**MOBILE LEGEND**

| Байр | Компани | Баг |
|---|---|---|
| 1 | "ДЦС-4" ТӨХК ЦЦ | "MTS" баг |
| 2 | "УБЦТС" ТӨХК | "Tulgatan" баг |
| 3 | "ДЦС-4" ТӨХК ХА | "WYS" баг |

*Шилдэг тоглогч*

"ДЦС-4" ТӨХК-ийн МЦ-ийн "MTS" багийн тоглогч JAKI




Нийлбэр багийн дүнгээр "ДЦС-4" ТӨХК-ийн Залуучуудын холбоо **ШИЛЖИН ЯВАХ ЦОМЫН** эзнээр тодорлоо.



*PUBG тэмцээний АВАРГА "ДЦС-4" ТӨХК - ЦЦ "ZS" баг*



*Mobile Legend-ийн АВАРГА "ДЦС-4" ТӨХК - МЦ, ЗА-ны "MTS" баг*

# КОМПАНИЙН АЖИЛТНУУДЫН ДУНД УЛАМЖЛАЛ БОЛОН ЗОХИОН БАЙГУУЛАГДДАГ 12 ДАХЬ УДААГИЙН ИЛТГЭЛИЙН УРАЛДААНЫ УДИРДАМЖ

## НЭГ. ЗОРИЛГО

Компанийн алба, хэлтэс, цех, нэгж, хэсгүүдэд байгаа техник, технологийн хүндрэлтэй асуудлуудыг шийдвэрлэх, олон улсад нэвтэрч буй шинэ техник, технологийг компанид нэвтрүүлэх, өөрсдийн хийсэн судалгааны ажлын үр дүнг хамт олонд хүргэж мэдээлэх үйл ажиллагаар зохион байгуулах, судалгаа шинжилгээний ажилд сонирхолтой ажилтны идэвх санаачлагыг дэмжих, өрнүүлэх үндсэн зорилготой.

## ХОЁР. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Компанийн хэтийн зорилт, өнөөгийн үйл ажиллагааны хүрээнд инноваци шингэсэн бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ, шинэ техник технологийг нэвтрүүлэхэд шаардагдах асуудлыг судлан, улмаар үйлдвэрлэлд нэвтрүүлэх, станцын эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх нөхцлийг бий болгоход оршино.

## ГУРАВ. ИЛТГЭЛИЙН СЭДЭВИЙН ЧИГЛЭЛ, НӨХЦӨЛ, ШААРДЛАГА

**Илтгэлийн сэдвийн чиглэл:**

1. Шинэ ажил үйлчилгээ гаргах
2. Шинэ бүтээгдэхүүн бий болгох
3. Шинэ техник, технологи нэвтрүүлэх
4. Явцуу шат дамжлагыг илрүүлэх, арилгах
5. Ажилдаа нэвтрүүлсэн ололт амжилтыг нээн илрүүлэх
6. Асуудал дэвшүүлсэн гэх мэт чиглэлүүдээр илтгэгч илтгэлээ бэлтгэж оролцоно.

Шилдэг, шинэ санал санаачлагын ажлыг компанид нэвтрүүлэх ажлын эхний шалгуур нь тухайн илтгэл байх бөгөөд гаргасан шинэ санаагаа ажил болгох нөхцлийг бүрдүүлж өгнө.

Мөн алба, хэлтэс, цех, нэгжийн жилийн ажлын зорилго, зорилтоо биелүүлэх, ажил хэрэг болгох ажлын биелэлтийн үндсэн шалгуур нь тухайн илтгэл байх бөгөөд асуудалд тооцоо судалгаатай, шинжлэх ухаанчаар хандах үзлийг төлөвшүүлэхэд чиглэгдэнэ.

**Илтгэлийн уралдааны нөхцөл:**

Илтгэлийн уралдааныг Судалгаа Хөгжлийн Албанаас зохион байгуулах бөгөөд компанийн бүх ажиллагсад өөрсдийн бэлтгэсэн илтгэлээрээ нээлттэй оролцох боломжтой. Илтгэлийн уралдаанд ажилтан дангаараа болон баг, хамт олноороо зохион байгуулалттай оролцож болно.

Илтгэлийн уралдааныг хоёр үе шаттай дүгнэн явуулна. Эхний шатанд ирүүлэх материалыг 2024 оны 06-р сарын 20-ны 09-15 цагийн хооронд СХА-ны 313 тоотод хүлээн авна.

Уралдааныг дүгнэх комисс, ирүүлсэн илтгэлүүдтэй танилцаж, шалгарсан илтгэгч нарт ажлын 14 өдрийн өмнө мэдэгдэнэ.

Уралдааны дараагийн шатанд тэнцсэн илтгэлийг 2024 оны 10 дугаар сарын 15–ны өдөр Дөл танхимд зохион явуулна.

**Илтгэлийн материалын шаардлага:**

Илтгэлийн уралдаанд оролцож буй материалууд урд өмнө Техникийн Зөвлөлийн Хуралаар орж хэлэлцэгдэж, компанид ажил хэрэг болж, нэвтэрч эхлээгүй шинэ санаа, шинэлэг бүтээл байх шаардлагатай.

Уралдаанд оролцох илтгэл нь А4 хэмжээс бүхий цаасан дээр 20 хүртэл нүүр байж болох ба танилцуулах хугацаа 15 минутаас ихгүй байна.

Баримт бичгийн бүрдлүүд нь хэвлэмэл хуудсанд тавигдах нэгдмэл шаардлага, стандартын дагуу хийгдсэн байна. Үүнд:

- Хуудасны дээд, доод талаас 3 см, баруун зүүн талаас 2,5 см–ийн зайтай
- Үсгийн фонд: Arial
- Үсгийн өндөр : 12 point
- Мөр хоорондын зай: 1,5 мөр

**Илтгэлийн бүтэц нь:** Оршил, Үндсэн хэсэг ( а. Судалгааны хэсэг, б. Эдийн засгийн тооцоо, в. Дүн шинжилгээ) Дүгнэлт, Хавсралт хэсэг.

ЖИЧ: Түлхүүр үг, тайлбар материал, арга зүй, үр дүн, график, зураг, хүснэгт, ашигласан ном зохиол, эх материал гэх мэт зүйлийг оруулсан байх.

Эхний шатанд оролцох илтгэлийг **Office Word** программ дээр бэлтгэж заасан хугацаанд ирүүлсэн байна.

Илтгэгч өөрийн овог нэр, цээж зураг, боловсрол, төгссөн сургууль, хашиж буй албан тушаал, цех нэгж (алба, хэлтэс, цех, нэгж), холбоо барих утас, е-майл хаягийг тодорхой бичсэн анкетийг бөглөж хавсралтаар ирүүлнэ.

Дараагийн шатанд танилцуулагдах материалаа **Office Powerpoint**, программ дээр бэлтгэн, мөн заасан хугацаанд ирүүлсэн байна.

**Хугацаа хоцорч ирүүлсэн материалыг хүлээн авах боломжгүй болно.**

## ДӨРӨВ. УРАЛДААНЫГ ДҮГНЭХ

**I шатны шалгаруулалт:** Ирүүлсэн бүх илтгэлийг үнэлэхдээ доорх үзүүлэлт тус бүрээр оноо өгч болзол хангасан илтгэлүүдийг 2-р шатанд шалгаруулан хэлэлцүүлэхээр үлдээнэ.

- Илтгэлд тавигдах шаардлага хангасан эсэх 1 - 5 оноо
- Судалгааны арга зүй, онолын тооцоолол, судлагдсан байдал 1 - 10 оноо
- Судалгаа, шинжилгээний ажлын гүйцэтгэл 1 - 5 оноо
- Эдийн засгийн үр ашиг, хэмнэлтийн тооцоо хийгдсэн байдал 1 - 15 оноо
- Судалгааны ажлын ач холбогдол, үр дүн 1 - 20 оноо

Дундаж оноогоор эхний 8 байрт шалгарсан илтгэлийг дараагийн сонсох шатанд шалгаруулан оролцуулна.

**II шатны шалгаруулалт:** Нийтэд танилцуулагдах илтгэлүүдийг доорх үзүүлэлтүүдээр үнэлгээ өгч шалгаруулна.

- Сэдвийн агуулга ач холбогдол 1 – 8 оноо
- Байгууллагад хэрэгжүүлэх шаардлагатай эсэх. 1 – 8 оноо
- Судалгааны ажлын гүйцэтгэл 1 – 8 оноо
- Асуултанд оновчтой хариулж байгаа эсэх 1 – 8 оноо
- Илтгэлд бэлдсэн байдал, илтгэх ур чадвар 1 – 8 оноо

Шүүгчдийн үнэлгээгээр дундаж оноогоор хамгийн их оноо авсан дараалаар илтгэлийг шалгаруулна.

## ТАВ. УРАЛДААНЫГ ШАЛГАРУУЛАХ КОМИСС

Комиссын даргаар компанийн ерөнхий инженер, гишүүдээр ХА, СХА-ны дарга нар мөн ШУТИС, ЭХС-аас цахилгаан, дулааны мэргэжлийн, эрдмийн цол зэрэгтэй 2 багш байна. Комиссын нарийн бичгийн даргаар СХА-ны ЗБТСХ-ийн патентын мэргэжилтэн оролцон ажиллана.

## ЗУРГАА. ШАГНАЛ УРАМШУУЛАЛ

- Тэргүүн байр (нэг), Өргөмжлөл 2 500 000₮
- Дэд байр (нэг), Өргөмжлөл 2 000 000₮
- Гутгаар байр (нэг), Өргөмжлөл 1 500 000₮
- Шагналт байр (нэг), Өргөмжлөл 1 000 000₮
- Тусгай шагнал (дөрөв), Батламж 250 000₮

Зохион байгуулах комисс